



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ханх сумын Хүүхдийн цэцэрлэгийн.2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/124/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

Мөрөн сум

2022 он

Хөвсгөл аймаг дахь Аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 99900662 Цахим хаяг: [Baterdenee@audit.gov.mn](mailto:Baterdenee@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [tegsh0416@yahoo.com](mailto:tegsh0416@yahoo.com)

Ньюбаланс Аудит ХХК-ийн

Захирал, чанарын хяналтын менежер Б.Лхагвадорж

Утас: 99101901 Цахим хаяг: [newbalance.lhagvaa@gmail.com](mailto:newbalance.lhagvaa@gmail.com)

Аудитор: Д.Гэрэлчулуун

Утас: 99509636 Цахим хаяг: [d.gerlee98@gmail.com](mailto:d.gerlee98@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

---

**Агуулга**

---

|  |    |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт .....   | 2  |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                 | 4  |
| 3. Аудитын тайлан.....   | 10 |
| 3.1 Ерөнхий зүйл.....  | 10 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....                       | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....                            | 10 |
| 3.4 Материаллаг байдал .....   | 11 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....                                  | 11 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....                        | 11 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....                   | 12 |
| 3.8 Аудитын гол асуудал .....  | 12 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 13 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....                                      | 13 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....                              | 13 |
| 4. Аудитын илрүүлэлт .....   | 13 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                          | 11 |

---

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ЗДТГ     | Засаг даргын Тамгын газар                                   |
| ЗГНХ     | Засгийн газрын нөөц хөрөнгө                                 |
| ЗДНХ     | Засаг даргын нөөц хөрөнгө                                   |
| НА       | Нягтлах ажил  |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                                 |
| ИТХ      | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                                |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/193  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ж.УРАНЧИМЭГ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ханх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ханх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБАТАР

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

|            |   |                       | /Төгрөгөөр/           |
|------------|---|-----------------------|-----------------------|
| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       |
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>67,598,613.30</b>  | <b>90,974,477.00</b>  |
| <b>31</b>  | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>   | 00.00                 | 00.00                 |
| 31211      | Төрийн сангийн харилцах   | 00.00                 | 00.00                 |
| <b>33</b>  | <b>АВЛАГА</b>   | 00.00                 | 00.00                 |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 67,598,613.30         | 90,974,477.00         |
| <b>351</b> | <b>Түүхий эд материал</b>   | 1,835,700.00          | 1,835,700.00          |
| 35110      | Тусгай зориулалттай материал  | 1,800,000.00          | 1,800,000.00          |
| 35130      | Эм боох материал  | 35,700.00             | 35,700.00             |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>  | 65,762,913.30         | 89,138,777.00         |
| 35410      | Бичиг хэргийн материал  | 1,851,700.00          | 2,195,500.00          |
| 35420      | Аж ахуйн материал   | 44,560,318.40         | 54,924,418.40         |
| 35440      | Түлш, шатах тослох материал   | 6,000,030.90          | 4,618,558.60          |
| 35450      | Барилгын засварын материал  | 00.00                 | 3,818,200.00          |
| 35460      | Хүнсний материал  | 8,204,864.00          | 12,579,373.00         |
| 35470      | Бусад хангамжийн материал   | 5,146,000.00          | 11,002,727.00         |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>317,548,409.18</b> | <b>329,505,672.32</b> |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 317,548,409.18        | 329,505,672.32        |
| <b>392</b> | <b>Биет хөрөнгө</b>   | 308,578,409.18        | 320,535,672.32        |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 293,681,190.00        | 293,681,190.00        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | -13,366,511.76        | -20,049,767.64        |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 33,826,429.00         | 39,399,700.00         |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | -14,835,063.95        | -8,014,104.96         |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 23,076,936.00         | 27,331,503.00         |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | -16,300,670.11        | -14,308,948.08        |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 9,343,000.00          | 9,343,000.00          |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | -9,343,000.00         | -9,343,000.00         |
| 39217      | Ном   | 2,496,100.00          | 2,496,100.00          |
| <b>393</b> | <b>Биет бус хөрөнгө</b>   | 8,970,000.00          | 8,970,000.00          |
| 39301      | Програм хангамж   | 300,000.00            | 300,000.00            |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл   | -300,000.00           | -300,000.00           |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 8,970,000.00          | 8,970,000.00          |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>385,147,022.48</b> | <b>420,480,149.32</b> |
| <b>413</b> | <b>Өглөг</b>  | 00.00                 | 00.00                 |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>385,147,022.48</b> | <b>420,480,149.32</b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 385,147,022.48        | 420,480,149.32        |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 556,715,073.00        | 556,715,073.00        |
| 51101      | Өмч: - төрийн   | 556,715,073.00        | 556,715,073.00        |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | -179,683,443.20       | -144,350,316.36       |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | -179,683,443.20       | -179,683,443.20       |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | 00.00                 | 35,333,126.84         |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 8,115,392.68          | 8,115,392.68          |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>385,147,022.48</b> | <b>420,480,149.32</b> |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
|             |  |                       | /Төгрөгөөр/           |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>296,642,200.00</b> | <b>298,395,867.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>8,695,500.00</b>   | <b>12,224,834.00</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 8,695,500.00          | 12,224,834.00         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 8,695,500.00          | 12,224,834.00         |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого  | 8,695,500.00          | 12,224,834.00         |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>22,818,200.00</b>  | <b>12,992,733.00</b>  |
| 131007      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих   | 265,128,500.00        | 273,178,300.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 00.00                 | 174,533.00            |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00                 | 174,533.00            |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | <b>22,818,200.00</b>  | <b>12,818,200.00</b>  |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 22,818,200.00         | 12,818,200.00         |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>286,057,909.94</b> | <b>263,060,567.66</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>286,057,909.94</b> | <b>263,060,567.66</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 271,518,109.94        | 262,070,936.27        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | 191,254,865.00        | 194,989,395.00        |
| 210101      | Үндсэн цалин   | 191,254,865.00        | 194,989,395.00        |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 24,407,243.00         | 26,334,073.61         |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 16,757,047.00         | 25,334,073.61         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 1,912,549.00          | 00.00                 |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 1,530,039.00          | 00.00                 |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 382,510.00            | 1,000,000.00          |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 3,825,098.00          | 00.00                 |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | 10,871,106.00         | 9,694,820.00          |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 2,404,406.00          | 2,017,720.00          |
| 210302      | Түлш, халаалт  | 5,500,000.00          | 6,915,000.00          |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 2,966,700.00          | 762,100.00            |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 10,697,693.00         | 3,572,152.30          |
| 210401      | Бичиг хэрэг  | 370,100.00            | 00.00                 |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 1,665,194.00          | 1,686,652.30          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 213,500.00            | 187,500.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 2,053,000.00          | 00.00                 |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 2,088,499.00          | 1,698,000.00          |
| 210408      | Бараа материал акталсны зардал   | 4,307,400.00          | 00.00                 |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | 17,737,545.00         | 10,183,924.00         |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл  | 00.00                 | 174,533.00            |
| 210502      | Хоол, хүнс   | 17,737,545.00         | 10,009,391.00         |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 245,000.00            | 506,100.00            |
| 210702      | Дотоод албан томилолт  | 245,000.00            | 506,100.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | 729,700.00            | 550,000.00            |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 429,700.00            | 200,000.00            |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох   | 300,000.00            | 350,000.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | 15,574,957.94         | 16,240,471.36         |

Ханх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|             |   |                      |                      |
|-------------|---|----------------------|----------------------|
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                         | 2,960,200.00         | 2,499,800.00         |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                        | 12,614,757.94        | 13,740,671.36        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                                   | <b>14,539,800.00</b> | <b>989,631.39</b>    |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                             | <b>340,000.00</b>    | <b>00.00</b>         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                   | 340,000.00           | 00.00                |
| <b>2135</b> | <b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b> | <b>14,199,800.00</b> | <b>989,631.39</b>    |
| 213503      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                     | 14,199,800.00        | 989,631.39           |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                 | <b>10,584,290.06</b> | <b>35,335,299.34</b> |
| <b>225</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                    | <b>00.00</b>         | <b>2,172.50</b>      |
| 225001      | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                            | 00.00                | 2,172.50             |
| <b>4</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>           | <b>00.00</b>         | <b>-2,172.50</b>     |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                            | <b>10,584,290.06</b> | <b>35,333,126.84</b> |

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| / төгрөгөөр / |                                       |                                 |                       |                   |   |
|---------------|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| Код           | Үзүүлэлт                              | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
| C01           | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 556,715,073.00                  | 8,115,392.68          | -190,267,733.26   | 374,562,732.42                          |
| C03           | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 556,715,073.00                  | 8,115,392.68          | -190,267,733.26   | 374,562,732.42                          |
| C07           | Тайлант үеийн үр дүн                  | 00.00                           | 00.00                 | 10,584,290.06     | 10,584,290.06                           |
| C08           | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 556,715,073.00                  | 8,115,392.68          | -179,683,443.20   | 385,147,022.48                          |
| D01           | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 556,715,073.00                  | 8,115,392.68          | -179,683,443.20   | 385,147,022.48                          |
| D03           | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 556,715,073.00                  | 8,115,392.68          | -179,683,443.20   | 385,147,022.48                          |
| D08           | Тайлант үеийн үр дүн                  | 00.00                           | 00.00                 | 35,333,126.84     | 35,333,126.84                           |
| D09           | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 556,715,073.00                  | 8,115,392.68          | -144,350,316.36   | 420,480,149.32                          |

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| /Төгрөгөөр/ |   |                       |                       |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| Дансны код  | Үзүүлэлт                                      | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>         |                       |                       |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b> | <b>290,228,065.00</b> | <b>286,171,033.00</b> |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>          | <b>290,228,065.00</b> | <b>286,171,033.00</b> |
| 131007      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих      | 265,128,500.00        | 273,178,300.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>            | <b>00.00</b>          | <b>174,533.00</b>     |

Ханх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|             |  |                       |                       |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00                 | 174,533.00            |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | <b>22,818,200.00</b>  | <b>12,818,200.00</b>  |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 22,818,200.00         | 12,818,200.00         |
| <b>1340</b> | <b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>  | <b>2,281,365.00</b>   | <b>00.00</b>          |
| 134001      | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих   | 2,281,365.00          | 00.00                 |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>   | <b>286,448,065.00</b> | <b>266,839,033.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>286,448,065.00</b> | <b>266,839,033.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>269,626,900.00</b> | <b>265,849,401.61</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | <b>189,589,600.00</b> | <b>194,989,400.00</b> |
| 210101      | Үндсэн цалин   | 153,811,965.00        | 146,112,361.00        |
| 210102      | Нэмэгдэл   | 22,378,377.00         | 35,174,451.00         |
| 210104      | Урамшуулал   | 13,399,258.00         | 13,702,588.00         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | <b>25,594,700.00</b>  | <b>25,334,068.61</b>  |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 18,011,100.00         | 17,950,446.00         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 1,895,900.00          | 2,031,676.00          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 1,516,800.00          | 1,560,000.00          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 379,100.00            | 344,730.71            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 3,791,800.00          | 3,447,215.90          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | <b>11,000,000.00</b>  | <b>9,000,000.00</b>   |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 2,224,200.00          | 2,000,000.00          |
| 210302      | Түлш, халаалт  | 6,000,000.00          | 6,000,000.00          |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 2,775,800.00          | 1,000,000.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | <b>11,039,900.00</b>  | <b>13,611,833.00</b>  |
| 210401      | Бичиг хэрэг  | 464,300.00            | 187,600.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 2,000,000.00          | 2,000,000.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 213,500.00            | 187,500.00            |
| 210404      | Ном, хэвлэл  | 179,300.00            | 156,200.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 2,240,000.00          | 174,533.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 5,942,800.00          | 10,906,000.00         |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | <b>25,491,800.00</b>  | <b>15,071,300.00</b>  |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл  | 2,471,000.00          | 62,400.00             |
| 210502      | Хоол, хүнс   | 14,826,600.00         | 14,383,900.00         |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 8,194,200.00          | 625,000.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | <b>1,220,000.00</b>   | <b>3,818,200.00</b>   |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 1,220,000.00          | 00.00                 |
| 210604      | Урсгал засвар  | 00.00                 | 3,818,200.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>00.00</b>          | <b>506,100.00</b>     |
| 210702      | Дотоод албан томилолт  | 00.00                 | 506,100.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | <b>300,000.00</b>     | <b>550,000.00</b>     |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 00.00                 | 250,000.00            |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох   | 300,000.00            | 300,000.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | <b>5,390,900.00</b>   | <b>2,968,500.00</b>   |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 319,000.00            | 468,700.00            |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 5,071,900.00          | 2,499,800.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>16,821,165.00</b>  | <b>989,631.39</b>     |

Ханх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|        |  |                      |                       |
|--------|--|----------------------|-----------------------|
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 2,621,365.00         | 00.00                 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж                                       | 2,281,365.00         | 00.00                 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                                    | 340,000.00           | 00.00                 |
| 2135   | <b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                  | 14,199,800.00        | 989,631.39            |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 14,199,800.00        | 989,631.39            |
| 3      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                    | <b>3,780,000.00</b>  | <b>19,332,000.00</b>  |
|        | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                   | <b>00.00</b>         | <b>00.00</b>          |
| 5      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | <b>3,780,000.00</b>  | <b>19,332,000.00</b>  |
| 22     | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>3,780,000.00</b>  | <b>19,332,000.00</b>  |
| 2200   | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | 3,780,000.00         | 19,332,000.00         |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | 3,780,000.00         | 19,332,000.00         |
| 6      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b>-3,780,000.00</b> | <b>-19,332,000.00</b> |
|        | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                           | <b>00.00</b>         | <b>00.00</b>          |
| 7      | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                     | <b>00.00</b>         | <b>00.00</b>          |
| 8      | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | 00.00                | 00.00                 |
| 9      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                           | 00.00                | 00.00                 |
| 10     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                          | 00.00                | 00.00                 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт  | Тайлант оны           |                |
|-----------------------|---|-----------------------|----------------|
|                       |   | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| 1                     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл      |                       |                |
| 2                     | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>              | 285,996,500.00        | 285,006,868.61 |
| 21                    | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                  | 285,996,500.00        | 285,006,868.61 |
| 210                   | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                | 285,996,500.00        | 285,006,868.61 |
| 2101                  | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>              | 194,989,400.00        | 194,989,400.00 |
| 210101                | Үндсэн цалин  | 137,508,400.00        | 146,112,361.00 |
| 210102                | Нэмэгдэл  | 44,570,700.00         | 35,174,451.00  |
| 210104                | Урамшуулал  | 12,910,300.00         | 13,702,588.00  |
| 2102                  | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | 26,323,700.00         | 25,334,068.61  |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                    | 18,524,000.00         | 17,950,446.00  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал                                    | 1,949,900.00          | 2,031,676.00   |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                     | 1,560,000.00          | 1,560,000.00   |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                  | 390,000.00            | 344,730.71     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                 | 3,899,800.00          | 3,447,215.90   |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>      | 9,000,000.00          | 9,000,000.00   |
| 210301                | Гэрэл, цахилгаан                                      | 2,000,000.00          | 2,000,000.00   |
| 210302                | Түлш, халаалт   | 6,000,000.00          | 6,000,000.00   |
| 210303                | Цэвэр, бохир ус                                       | 1,000,000.00          | 1,000,000.00   |
| 2104                  | <b>Хангамж, бараа материалын зардал</b>               | 13,437,300.00         | 13,437,300.00  |

Ханх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|             |  |                       |                       |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210401      | Бичиг хэрэг  | 187,600.00            | 187,600.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 2,000,000.00          | 2,000,000.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 187,500.00            | 187,500.00            |
| 210404      | Ном, хэвлэл  | 156,200.00            | 156,200.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 10,906,000.00         | 10,906,000.00         |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | <b>15,071,300.00</b>  | <b>15,071,300.00</b>  |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                                      | 62,400.00             | 62,400.00             |
| 210502      | Хоол, хүнс   | 14,383,900.00         | 14,383,900.00         |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 625,000.00            | 625,000.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>23,150,200.00</b>  | <b>23,150,200.00</b>  |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 11,742,000.00         | 11,742,000.00         |
| 210602      | Тавилга  | 7,590,000.00          | 7,590,000.00          |
| 210604      | Урсгал засвар  | 3,818,200.00          | 3,818,200.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>506,100.00</b>     | <b>506,100.00</b>     |
| 210702      | Дотоод албан томилолт  | 506,100.00            | 506,100.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>550,000.00</b>     | <b>550,000.00</b>     |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 250,000.00            | 250,000.00            |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 300,000.00            | 300,000.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>2968500.00</b>     | <b>2968500.00</b>     |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 468,700.00            | 468,700.00            |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 2,499,800.00          | 2,499,800.00          |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | <b>285,996,500.00</b> | <b>285,996,500.00</b> |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | <b>273,178,300.00</b> | <b>273,178,300.00</b> |
| 131007      | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих                             | 273,178,300.00        | 273,178,300.00        |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | <b>12,818,200.00</b>  | <b>12,818,200.00</b>  |
| 132001      | Орон нутгийн төсвөөс   | 12,818,200.00         | 12,818,200.00         |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>  | <b>18.00</b>          | <b>18.00</b>          |
| 620001      | Удирдах ажилтан  | 01.00                 | 01.00                 |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан  | 08.00                 | 08.00                 |
| 620003      | Үйлчлэх ажилтан  | 09.00                 | 09.00                 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт   | / төгрөгөөр / |            |
|------------|--|---------------|------------|
|            |  | Өмнөх он      | Гүйцэтгэл  |
|            | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   |               |            |
| I          | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН  |               | 174,500.00 |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ  |               | 174,500.00 |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  |               | 174,500.00 |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал   |               | 174,500.00 |
| 210405     | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  |               | 174,500.00 |
| II         | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР   |               | 174,500.00 |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого  |               | 174,500.00 |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө |               | 174,500.00 |

---

### 3. Аудитын тайлан

---

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ханх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Гэрэлчулуун, аудиторын туслах С.Гэрэлдаваа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Лхагвадорж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Ханх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ханх сумын хүүхдийн цэцэрлэг нь “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үйл ажиллагааг эрхэмлэн сургуулийн өмнөх насны хүүхдийн хэрэгцээ сонирхолд нийцсэн таатай орчинг бүрдүүлэн хүртээмжтэй чанартай үйлчилгээг үзүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43-р тогтоол, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэх тухай” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ханх сумын Хүүхдийн цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 273.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ханх сумын Хүүхдийн цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39.2 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт    |
|---|----------------|-----------------|-------------|
| Б   | 1              | 2               | 3=2-1       |
| Авлага  | 0.0            | 0.0             |             |
| Бараа материал                                    | 67.5           | 94.6            | 27.3        |
| Биет хөрөнгө                                      | 308.5          | 320.5           | 11.9        |
| Биет бус хөрөнгө                                  | 8.9            | 8.9             |             |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>385.1</b>   | <b>424.3</b>    | <b>39.2</b> |
| Дансны өглөг                                      | 0.0            | 0.0             |             |
| Засгийн газрын хувь оролцоо                       | 556.7          | 556.7           |             |
| Хуримтлагдсан үр дүн                              | -179.6         | -144.4          | 39.2        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>385.1</b>   | <b>424.3</b>    | <b>39.2</b> |

Бараа материалын дансны үлдэгдэл 94.6 сая төгрөг болж 27.3 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материалын нөөц өссөнтэй холбоотой байна.

Биет хөрөнгийн дүн 320.5 сая төгрөг болж 11.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн дүн, 9.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй хөрөнгийг данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо данс 556,7 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн -144.4 сая төгрөг, Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 8.1 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 298.3 сая төгрөг нийт зардал 263.0 сая төгрөг тайлант үеийн үр дүн 35.3 сая төгрөг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант хугацааны үр дүн 35.3 сая төгрөгөөр нөлөөлж нийт цэвэр өмчийн дүн 385.1 сая төгрөг байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ханх сумын Хүүхдийн цэцэрлэг 2021 оны төсвийн төслийг 299.9 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд 294.5 сая төгрөгөөр анх баталж, төсвийн жилд батлагдсан төсөвт 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу 1 удаа төсвийн тодотгол хийж 286.0 сая төгрөгийн төсөв баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Ханх сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 онд 286.0 сая төгрөг батлагдсанаас 273.1 сая төгрөгийн улсын төсвөөс, 12.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийт 286.0 сая төгрөгийн санхүүжих эх үүсвэрээс 285.0 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж 1.0 сая төгрөг хэмнэж орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

71801 буюу Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 4 зориулалт арга хэмжээнд зарцуулсан гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл :

Хүснэгт 2. Төсвийн хөтөлбөр, арга хэмжээ / Сая төгрөг/

| Зориулалт, арга хэмжээний код | Арга хэмжээний нэр   | Төсөв | Гүйцэтгэл | зөрүү | Тайлбар      |
|-------------------------------|--|-------|-----------|-------|--------------|
| 81834                         | Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 169.6 | 168.6     | 1.0   | төвлөрүүлсэн |
| 81835                         | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах                             | 89.1  | 89.1      |       | 00           |
| 80109                         | ТШЗ ийн байгууллагуудын тогтмол зардал                             | 12.8  | 12.8      |       |              |
| 81807                         | Хүүхдийн хоол  | 14.4  | 14.4      | 00    |              |
| Дүн                           |  | 286.0 | 285.0     | 1.0   |              |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар Аймгийн боловсролын газраас 0.1 сая төгрөгийг хүлээн авч ариутгалд 0.1 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Корона вирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Ханх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газрын 43 дугаар тогтоолоор баталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. Тухайн төсвийн жилд батлагдсан төсөвт төсвийн зохицуулалт хийж хүүхдийн хоолны зардлаас 30.7 сая төгрөг, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 6.3 сая төгрөг, гэрэл цахилгааны зардлаас 2.0 сая төгрөг, томилолтын зардлаас 0.6 сая төгрөг нийт 39.7 сая төгрөг тус тус хасаж, багаж техник хэрэгсэлийн зардалд 11.7 сая төгрөг, тавилга худалдан авах зардалд 7.5 сая төгрөг, БҮТЭЗ ийн зардалд 9.9 сая төгрөг, урсгал засварын зардалд 2.0 сая төгрөг нийт 31.2 сая төгрөгийг нэмж зохицуулалт хийсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих 396.0 сая төгрөгийн 65 мэдээллээс 342.5 сая төгрөгийн 63 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 53.5 сая төгрөгийн 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ын хэрэгжилтийг хянан үзлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг аудитаар дахин хянахад шилэн дансны хууль хэрэгжүүлж ажиллах талаар зөрчил давтагдаж энэ жил 15 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар онцлон анхаарах зүйл байхгүй болно.

### **4. Аудитын илрүүлэлт**

2021 оны 9 сард БСШУЯ наас хандиваар ирсэн 3.9 сая төгрөгийн өртөг бүхий 1 ширхэг 2 дугаар хоолны тогоог бараа материал болон үндсэн хөрөнгө дансанд давхар орлого авч бүртгэсэн алдаа илэрсэн.

#### **4.1 Залруулсан алдаа**

Давхардуулан орлого авсан 3.9 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийн орлогын дүн, бараа материал дансны үлдэгдэл, үр дүн дансуудыг тус тус 3.9 сая төгрөгөөр бууруулан санхүүгийн тайланд залруулав.

#### **4.2 Төлбөрийн акт**

Ханх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### **4.3 Албан шаардлага**

Ханх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

#### **4.4 Зөвлөмж**

Ханх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй болно

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Аудитын илрүүлэлт**

Аудитаар хөрөнгө давхар орлого авсан 3.9 сая төгрөгийн алдаа илэрсэн

**1.1 Залруулсан алдаа**

Давхардуулан орлого авсан 3.9 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр үнэ төлбөргүй ирсэн өрөнгийн орлогын дүн, бараа материал дансны үлдэгдэл, үр дүн дансуудыг тус тус 3.9 ая төгрөгөөр бууруулан санхүүгийн тайланд залруулав.

**1.2 Төлбөрийн акт**

Ханх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

**1.3 Албан шаардлага**

Ханх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

**1.4 Зөвлөмж**

Ханх сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй болно

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**ii. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |     | /сая төгрөгөөр/ |     |           |  |               |  |                 |  |         |  |
|-----|-------------------------------------|----------------------|-----|-----------------|-----|-----------|--|---------------|--|-----------------|--|---------|--|
|     |                                     |                      |     | Үүнээс          |     |           |  |               |  |                 |  |         |  |
|     |                                     | Тоо                  | Дүн | Тоо             | Дүн | Залруулга |  | Төлбөрийн акт |  | Албан шаардлага |  | Зөвлөмж |  |
| 1   | Ханх сумын Хүүхдийн цэцэрлэг        | 1                    | 3.9 | 1               | 3.9 |           |  |               |  |                 |  |         |  |

АУДИТЫН ТАЙЛАН:  
ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС  
ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР  
Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Э.БАТ-ЭРДЭНЭ  
Огноо:

АХЛАХ АУДИТОР:

Б.ТЭГШДЭЛГЭР  
Огноо:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИАС  
ХЯНАСАН:

ЗАХИРАЛ

Б.ЛХАГВАДОРЖ  
Огноо: 2022.02.22

БОЛОВСРУУЛСАН:  
АХЛАХ АУДИТОР

Д.ГЭРЭЛЧУЛУУН  
Огноо:

АУДИТЫН ТАЙЛАН:  
ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС  
ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР  
Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Э.БАТ-ЭРДЭНЭ  
Огноо:

АХЛАХ АУДИТОР:

Б.ТЭГШДЭЛГЭР  
Огноо:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИАС  
ХЯНАСАН:

ЗАХИРАЛ

Б.ЛХАГВАДОРЖ

---

Огноо:

БОЛОВСРУУЛСАН:  
АХЛАХ АУДИТОР

Д.ГЭРЭЛЧУЛУУН  
Огноо: